

Шалгалтын дүнгийн тухай

Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Засаг даргын баталсан 2022 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16 тоот удирдамжийн хүрээнд Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрүүл мэндийн тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, санал дүгнэлт гаргах замаар эрсдэлийг бууруулах, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажиллахад шалгалтын зорилго чиглэгдэв.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа:

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Т.Цэрэгбаяр ахалж, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч дотоод аудитор Б.Чулуунбат нар 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс ажлын 10 хоногт хийж гүйцэтгэв.

Гурав. Шалгалтад хамрагдсан асуудлууд:

Шалгалтад 2020 оноос 2021 оны даргын тушаал, санхүүгийн үндсэн баримтууд, тайлан тэнцлүүд, анхан шатны баримтууд хамрагдлаа.

Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл:

Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 1270001105 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 9052275 тоот регистрийн дугаартай, Төрийн сан банкны 100121220401 тоот, нэмэлт санхүүжилтийн 100121220001 тоот харилцах данстай, Эрдэнэцагаан сумын 2 дүгээр багийн нутаг дэвсгэрт оршдог, 2020, 2021 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх

ажилтан 21, үйлчлэх ажилтан 7 нийт 29 орон тоотойгоор “Үйлчлүүлэгчдэд ээлтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэхэд оршино” гэсэн зорилго тавин үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна

№	Байгууллагын нэр	Харилцах данс, банкны нэр	1 дүгээр гарын үсгийг	2 дугаар гарын үсгийг
1	Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв	ТСНД 100121220001	Г.Энхтуяа 2020.01.01-2021.12.31	Р.Баттулга 2020.01.01-2021.06.11 Ж.Сарантуяа 2021.06.12-2021.09.20 Б.Золжаргал 2021.09.20-2021.12.31
2	Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв	ТСНД 100121220401	Г.Энхтуяа 2020.01.01-2021.12.31	Р.Баттулга 2020.01.01-2021.06.11 Ж.Сарантуяа 2021.06.12-09.20 Б.Золжаргал 2021.09.20-2021.12.31

Тав: Өмнөх шалгалтын талаар:

1. Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 онд 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж дарга Г.Энхтуяа ээлжийн амралтын шийдвэргүй авсан зөрчилд 1 албан шаардлага үйлдсэний биелэлтийг ханган ажилласан байна.

2. 2021 онд 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, төсвийг зориулалт бус зарцуулсан 528.0 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлбөрийн 1 акт тогтоосныг барагдуулж ажилласан, шилэн дансны ил тод байдлыг хангаж ажиллаагүй, илүү цагийн хөлсийг олгоогүй 5659.6 мянган төгрөг, хөтөлбөр төслийн дотоод урсгал арга хэмжээний зардлыг шууд зардалд илэрхийлсэн 5116.2 мянган төгрөг, эм боох материалыг эмийн эргэлтийн сангаар дамжуулаагүй 36576.5 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 1 албан шаардлага үйлдэж шийдвэрлэсэн байна.

2. Аймгийн Төрийн аудитын газраас 2021 онд 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж “Хязгаарлалттай дүгнэлт” өгч, цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй 400.0 мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлбөрийн нэг акт тогтоож, шилэн данс мэдээллийн хугацааг хоцроосон, нийгмийн даатгалын тайланг 7545.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, батлагдсан төсвөөс 26071.1 мянган төгрөгөөр давуулан худалдан авалт хийсэн зөрчлүүдэд албан шаардлага өгч, нягтлан бодогчид хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.

3. Аймгийн Аудитын газраас 2022 онд 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгч, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон 1.6 сая төгрөг, хоолны хэмнэгдсэн төсвийг төвлөрүүлээгүй 0.8 сая

төгрөгт нөхөн төлбөрийн 2 акт тогтоож, шилэн дансны нэгдсэн сайтад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг мэдээлээгүй, нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалинг 2.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчилд 2 албан шаардлага, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн үр өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 86 ширхэг хөрөнгө байгаад зөвлөмж өгсөн байна.

Зургаа. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал:

-Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт байгууллагын хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийхэд:

Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар:

№	Орлогын эх үүсвэр	2020 он			2021он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын төсвөөс	406728.3	406728.3	-	465869.9	465869.9	-
2	Эрүүл мэндийн даатгалын төсвөөс санхүүжилт	55930.8	55930.8	-	68757.8	34639.7	34118.2
3	Орон нутгийн төсвөөс	28964.5	28964.5	-	32423.6	32423.6	-
4	Дээд шатны төсөв зөхирагчаас	18404.1	18404.1	-		233726.7	-233726.7
5	Туслах аж ахуйн орлого	400.0	400.0	-		500.0	-500
6	Бусад		80.0	-80.0		106.1	-106.1
7	Хандив					1000.0	-1000.0
	НИЙТ	510427.7	51050767	-80	567051.3	767766.0	-200714.7

Эрүүл мэндийн төв нь 2020 онд улсын төсвөөс 406728.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 18404.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 55930.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28964.5 мянган төгрөг, туслах аж ахуйгаа 400.0 мянган төгрөг, бусад орлого 80.0 мянган төгрөг, нийт 510507.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй, 48894.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, 21565.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Зардлыг гүйцэтгэлээр харуулбал: Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 337446.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 41180.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 23953.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 24913.0 мянган төгрөг, нормативт зардалд 44111.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 5579.1 мянган төгрөг, томилолтын зардалд 1982.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2917.5 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 5356.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 4503.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2021 онд улсын төсвөөс 465869.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 34639.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 32423.6 мянган төгрөг, дээд шатны төсөв

захирагчаас 233726.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 500.0 мянган төгрөг, хандиваар 1000.0 мянган төгрөг, бусад орлого 106.1 мянган төгрөг, нийт 767766.0 мянган төгрөгийн эх үүсвэртэй, 746592.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 2475.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд гаргаж ажилласан байна.

Зардлын гүйцэтгэлээр харуулбал: цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 484715.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 63112.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 27423.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 27064.7 мянган төгрөг, нормативт зардалд 92567.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4999.0 мянган төгрөг, томилолтын зардалд 350.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1010.6 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 2748.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 42600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 234832.8 мянган төгрөг төвлөрч, үүнээс цалин хөлсний зардалд 103590.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 16185.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 794.0 мянган төгрөг, нормативт зардалд 55937.5 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 201.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3822.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 41600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

2021 онд Монгол улсад ковид өвчин гарсантай холбогдуулан төсвийн зардал өмнөх онтой харьцуулахад 50.4 хувиар өссөн байна. Мөнгөн гүйлгээний тайланг хавсаргав.

-Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх:

Тус газар нь 2021 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 63402.1 мянган төгрөгийн авлагатай, өглөггүй илэрхийлсэн ч хяналт шалгалтын явцад хувь хүн, байгууллагаас авах 190.0 мянган төгрөг, байгууллагад төлөх 2825.1 мянган төгрөгийн өглөгийг /халаалтын өглөг/ тайлан балансад илэрхийлээгүй байна.

-Байгууллагын цалин хөлс тогтоох, олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явагдаж буй эсэхэд санхүүгийн хяналт хийхэд:

Íí	Àëááí óóøààèúí àíáèèèàè	Óäèðäàäõ	Ã¿éöýðäý õ	˘éé÷лэх	Á¿ää	Цалингийн зардал
2020	Ò°è°áè°ã°°	1	21	7	29	346788.9
	Ã¿éöýðäýè	1	21	7	29	337446.3
	Зөрүү	-	-	-	-	9342.6
2021	Төлөвлөгөө	1	21	7	29	405035.3

	Гүйцэтгэл	1	21	7	29	381125.1
	Зөрүү	-	-	-	-	23910.2

-Байгууллагын үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтын байдал, тооллого үнэн зөв чанартай хийгдсэн эсэх:

/Мянган төгрөгөөр/

№	Балансын зүйл	2020 он			2021 он		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Барилга байгууламж	403464.4	403464.4	-	403464.4	403464.4	-
2	Авто тээврийн хэрэгсэл	57200.0	180232.3	123032.3	180232.3	180232.3	-
3	Тоног төхөөрөмж	136346.2	136346.2	-	136346.2	149507.1	13161.0
4	Тавилга эд хогшил	48723.0	48723.0	-	48723.0	48723.0	
5	Бусад үндсэн/х	12570.0	12570.0	-	12570.0	12570.0	
6	Программ хангамж	770.0	770.0	-	770.0	770.0	
7	Бусад биет хөрөнгө	10772.0	10772.0	-	10772.0	10772.0	
	ДҮН	669845.6	792877.9	123032.3	792877.9	806038.9	13161.0

2020 онд БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар 123032.3 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийн хөрөнгө оруулсныг данс бүртгэлдээ тусгасан байна.

2021 онд төсвийн хөрөнгөөр 2475.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /хурууны хээ уншигч, зөөврийн компьютер/, хандив тусламжаар 10686.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /мөсөн ханатай хөргөгч, суурин компьютер/, нийт 13161.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд орлогоор тусгасан байна. Тус онуудад хөрөнгө актлаагүй байна.

Хоолны зардлын талаар:

2020 онд хүнсний материалын 653.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй, тайлант хугацаанд 6903.1 мянган төгрөгийн, хандиваар 139.2 мянган төгрөгийн хүнсний материал бэлтгэж 6940.9 мянган төгрөгийн зардал гарган, 754.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2021 онд төсвийн хөрөнгөөр 13350.5 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 13330.6 мянган төгрөгийн зардал гарган, 774.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Хүнсний материалыг “Отгон төгөл” ХХК-тай оны эхнээс эхлэн гэрээ байгуулж, сарын эхэнд худалдан авах материалын захиалгаа өгч татан авалт хийж сарын эцэст төлбөр тооцоогоо хийж хэвшсэн ба эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоог үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 сарын 23 ны өдрийн А/74 тоот тушаалаар баталсан журам, норм норматив болон Эрүүл мэндийн Яам нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан ковид 19 халдварын цар тахлын үеийн хоол тэжээлийн үеийн зөвлөмжүүдийг үндэслэн гаргасан хоолны өдөрлөгийн дагуу нярваас материалаа авч ажилласан байна. Сумын хэмжээнд махны төвлөрсөн хангамж байхгүй учраас мах худалдан авах талаар тендер зарлаж гэрээ байгуулах боломжгүй, мал эмнэлгийн шинжилгээний бичиг, гарал үүслийн бичгийг үндэслэн чанар байдлыг харгалзан худалдан авсан байна.

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн талаар:

Эрүүл мэндийн төв нь 2020, 2021 онуудад 53303.8 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, эм боох материалын тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

2020 онд материалын тайланд төсвийн хөрөнгөөр 36576.5 мянган төгрөгийн эм, боох материалыг, 36576.5 мянган төгрөгийн материалыг зарцуулж, үлдэгдэлгүй ажилласан байна.

2021 онд материалын тайланд төсвийн хөрөнгөөр 78016.9 мянган төгрөг, хандив тусламжаар 40839.4 мянган төгрөг, нийт 118856.3 мянган төгрөгийн эм боох материал хүлээн авч 118856.3 мянган төгрөгийн эм боох материалыг зарцуулж, үлдэгдэлгүй ажилласан байна.

Түүнчлэн Эрүүл мэндийн газраас 6856.5 мянган төгрөгийн үнэ бүхий 700 ширхэг түргэвчилсэн тест, мөн сумын Засаг даргын 2021.04.02-ны өдрийн А/59 тоот захирамжаар 3300.0 мянган төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг, 2021.04.02-ны өдрийн А/69 тоот захирамжаар 6300.0 мянган төгрөгийн 300 ширхэг, 2021.06.15-ны өдрийн А/225 тоот захирамжаар 6250.0 мянган төгрөгийн 500 ширхэг, 2021.09.03-ний өдрийн А/168 тоот захирамжаар 6250.0 мянган төгрөгийн 500 ширхэг, нийт 22100.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1500 ширхэг, мөн 2021 онд төсвийн хөрөнгөөр 4100.0 мянган төгрөгийн үнэ бүхий 300 ширхэг, ковидын шинжилгээний орлогоор 1500.0 мянган төгрөгийн үнэ бүхий 120 ширхгийг, нийт 2620 ширхэг ковидын түргэвчилсэн тестийг хүлээн авч иргэдэд төлбөртэй болон төлбөргүй шинжилгээ хийсэн байна.

2021 онд коронавирусын халдвар авсан нийт 483 иргэнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлж эмийн багц тарааснаас гэрээр эмчлүүлсэн 319 иргэнд 51040.0 мянган төгрөгийн, хэвтэн эмчлүүлсэн 164 иргэнд 160720.0 мянган төгрөгийг зарцуулж, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас 211760.0 мянган төгрөгийг нэхэмжилсэн байна.

Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хэрэгжилт:

Дотоод хяналт шалгалтын нэгжийг эмнэлгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “эрүүл мэндийн төвийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг мөрдлөг болгон дотоод хяналтын баг удирдамж боловсруулан батлуулж удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, тайлагнаж ажилласан байна. 2020 онд 4 чиглэлээр 22 ажлыг, 2021 онд 4 чиглэлээр 27 ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн байна. Дотоод хяналтын баг нь хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсронгуй болгож төлөвлөх, шалгалтын тайланг удирдлагад танилцуулах, илэрсэн асуудлын үндсэн шалтгааныг олж тогтоох, асуудлыг хэрхэн арилгах талаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Долоо. Шалгуулагч байгууллагын ололттой дэвшилттэй тал:

Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв нь улсын төсөв, хандив тусламж, төсвийн хөрөнгөөр нийт 136193.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт авч иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлсэн байна.

Найм: Шалгалтаар илрүүлсэн нийтлэг зөрчил, дутагдал, шалтгаан түүнээс гарч болзошгүй буюу гарсан хохирол, хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт:

1. Тус эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь 2020 онд 2495.7 мянган төгрөг, 2021 онд 329.5 мянган төгрөг, нийт 2825.1 мянган төгрөгийн халаалтын бодит өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 -д “хариуцлагатай байх”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр”, мөн хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг;

2. Жолооч Д.Болдод 2020.11.27-ны өдөр 2020 оны ээлжийн амралтыг биеэр эдлээгүй үеийн олговрыг тооцон олгохдоо 349.8 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна” гэж заасныг;

3. 2020.08.25-ны өдөр Хуран хоршоо ХХКруу 240.6 мянган төгрөг, 2020.12.24-ны өдөр Медбуян трейд ХХК-руу 492.6 мянган төгрөг, нийт 733.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн, үүссэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч

ажиллаагүй 2 жил болсон байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг;

4. 2021.02.10-ны өдөр нягтлан бодогч Р.Баттулгад 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосныг суутган тооцоогүй, шууд зардалд илэрхийлсэн, мөн 2020 оны 11 дүгээр сард А.Түвшинжаргалын гарт олгох цалингаас 197.9 мянган төгрөгийг үндэслэлгүй суутгасан, түүнчлэн 2021.06.02-ны өдөр Чоно харайх гол ХХК-руу 105.0 мянган төгрөг, Санхүүгийн тооцоолох групп ХХК-руу 33.0 мянган төгрөг 2021.08.30-ны өдөр жолооч Д.Болд-руу 52.0 мянган төгрөг, нийт 190.0 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлснийг авлагаар бүртгэлгүй шууд зардалд илэрхийлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, мөн хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг;

5. Нийгмийн эрүүл мэндийн төсөв болох 2020 оны 5116.2 мянган төгрөг, 2021 оны 1026.0 мянган төгрөг, нийт 6142.1 мянган төгрөгийг зарцуулахдаа нярвын тайлангаар дамжуулаагүй шууд зардалд илэрхийлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэж заасныг;

6. Ковидын шинжилгээний орлогыг лаборант Б.Батгэрэл нь эрүүл мэндийн төвийн дансанд төвлөрүүлээгүй гар дээрээс бэлнээр зарцуулж, орлогын үлдэгдэл болох 75.0 мянган төгрөгийг дутагдуулсан, түүнчлэн лаборантыг ээлжийн амралттай байх хугацаанд их эмч Б.Наранжаргалан, Н.Ууганбаяр нар ковидын шинжилгээ авч байсан ба тус шинжилгээний орлогоос 400.0 мянган төгрөгийг дутагдуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох

бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.4-д “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5-д “бүх орлого” гэж заасныг;

7. 2021 онд 2065.0 мянган төгрөгийн ковидын шинжилгээний төлбөр төвлөрсөн ба тус мөнгөн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.12-д “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана”, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264 / А/293 тоот тушаалын хоёрдугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-ын 2.5-д “Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэн, төрийн сан дахь төсвийн харилцах дансанд төвлөрүүлнэ”, Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 05, А/12 тушаалын хавсралт “Коронавируст халдвар /Ковид19/-ыг илрүүлэх шинжилгээг хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар”-ын 3 дахь хэсгийг

8. Эмнэлгийн дарга Г.Энхтуяагийн нөхөр болох жолооч Д.Болдод 2020 онд үр дүнгийн урамшуулал 165.9 мянган төгрөг, 2021 онд 1054.8 мянган төгрөг, нийт 1220.7 мянган төгрөгийг олгосон байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ”, 8.6- “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасныг;

9. Ковидын шинжилгээний оношлуур тестийг няравын тайлангаар дамжуулаагүй зарцуулсан, нийт 2620 ширхэгийг хүлээж авсан ба шинжилгээний бүртгэлээр 2089 ширхэг тестийг зарцуулж 531 ширхэг үлдэгдэлтэй байхаас 430 ширхэгийн үлдэгдэл бэлэн тоологдож, 101 ширхэг буюу 1262.5 мянган төгрөгийн шинжилгээний тестийг дутагдуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй

байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-д “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэж заасныг,

10. Шалгалтад хамрагдсан онуудад 2020 онд Андын элч ХХК-аас өгсөн 1000.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний хандив, иргэн А.Ганбаатарын өгсөн утлагын аппарат 2 ширхэг, иргэн Ш.Лхамсүрэнгээс өгсөн 2000.0 мянган төгрөгийн авто машины сэлбэг хэрэгсэл /4 ширхэг дугуй/, мөн 2021 онд Отгонтөгөл ХХК-аас өгсөн 10000.0 мянган төгрөгийн хандив болох гематологийн аппаратыг орлогод аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.3.4-д “төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.4-д “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5-д “бүх орлого” гэж заасныг;

11. Үнэ төлбөргүй хүлээн авсан түргэн тусламжийн зориулалттай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон фургон маркийн авто машиныг тоног төхөөрөмжийн хамт авто тээврийн хэрэгсэл дансанд 123032.3 мянган төгрөгөөр үнэлэн бүртгэсэн байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 86 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3-д “Хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд хандив, тусламж, бэлэглэл, зээл, төслийн шугамаар бий болсон хөдлөх эд хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцон данс бүртгэлд тусгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Ес: Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:

Тус газарт шалгалтын удирдамжийг танилцуулж, санхүүгийн баримтууд болон бусад холбогдох баримтыг хүлээн авч шалгалтыг эхэллээ. Шалгалтын явцад дарга, нягтлан бодогч, нярав, дотоод хяналт шалгалтын нэгжийн ажилтан нартай уулзаж шалгалтаар гарч

байгаа зөрчил дутагдлыг танилцуулж, цаашид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь хэсэгт “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулах” гэснийг үндэслэн шалгалтаар илэрсэн нийт 149728.6 мянган төгрөгийн зөрчлөөс 142395.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоохоор улсын ахлах байцаагчийн 3-н албан шаардлага үйлдэж, 7333.5 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн 9 салбар акт тогтоож шийдвэрлэв.

Арав. Шалгагдсан аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нийт 150203.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба зөрчлийг ангилахад нийт зөрчлийн 0.1 хувь буюу 190.0 мянган төгрөг нь зориулалт бусаар зарцуулсан, 0.6 хувь буюу 847.7 мянган төгрөг нь цалин хөлсийг илүү, дутуу олгосон, 1.9 хувь буюу 2825.1 мянган төгрөг нь өглөг үүсгээгүй, 0.3 хувь буюу 475.0 мянган төгрөг нь орлого төвлөрүүлээгүй, 0.5 хувь буюу 733.2 мянган төгрөг нь авлаг барагдуулаагүй, 12.7 хувь буюу 19142.1 мянган төгрөг нь данс бүртгэлд тусгаагүй, 1.2 хувь буюу 1737.5 мянган төгрөг нь ашиглаж дутагдуулсан, 82.7 хувь буюу 124253.0 мянган төгрөг нь бусад зөрчил тус тус эзэлж байна.

Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалтын байдал, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Тус эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь 3-н удаа солигдсон ба нягтлан бодогчийг солигдох үед төсөв, санхүү, эд хөрөнгийн тооллого тооцоог хийгээгүйгээс авлага, өглөгийн бодит үлдэгдлийг гаргаагүй, төсвийг илүү шилжүүлж шууд зардалд бичсэн, хандив тусламжийн хөрөнгө, бараа материалыг бүртгэлээр дамжуулалгүй гар дээрээс шууд зарцуулсан, шинжилгээний тест, орлого дутсан зэрэг олон алдаа зөрчил илэрсэн байна. Түүнчлэн ковидын шинжилгээний бүртгэлийг үрэгдүүлж хэдэн ширхэг тест зарцуулсан, хэдэн төгрөгийн орлого олсон, олсон орлогыг юунд зарцуулсан тодорхойгүй байгаа нь эмч, эмнэлгийн ажилтан, удирдлага, санхүү бүртгэл, тооцооны ажилтан нар ажилдаа хариуцлагагүй хандсанаас төсвийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бус зарцуулагдах эрсдэлийг үүсгэсэн байна.

Иймд эм, эмнэлгийн хэрэгслийг холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгж болон ерөнхий гэрээгээр худалдан авалтыг хийж байх, нягтлан бодох бүртгэлээ орлогыг орсон үед, зарлагыг гарсан үед бүртгэх, хандив тусламжийн орлогыг данс бүртгэлд тухай бүр бүртгэн авч байх, бэлэн

мөнгөний орлогыг журмын дагуу төрийн санд тухай бүр төвлөрүүлж байх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал

1. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж, өглөг, авлага үүсгэхгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах;

2. Төлбөртэй үйлчилгээний орлого олох журмыг баталж мөрдөх, олсон орлогыг үнэн зөв бүртгэн дансанд төвлөрүүлэх, орлогын бүртгэлийг архивлан холбогдох ажилтанд хүлээлгэн өгч байх;

3. Орлогыг орсон үед, зарлагыг гарсан үед нь бүртгэж тайлагнах;

4. Санхүү бүртгэл тооцооны ажилтныг солигдох үед санхүүгийн иж бүрэн тооллогыг хийдэг байх;

5. Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендер зарлах, худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж ажиллах;

6. Нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлж ажил гүйлгээг шууд зардалд бичихгүй байх;

7. Ажилчдын ажлын хариуцлага, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үүднээс дотоод хяналт шалгалтыг шалгалтын явцад өгсөн зөвлөмжийн дагуу зохион байгуулж ажиллах;

8. Танай байгууллагад хийсэн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хүргүүлж буй энэхүү зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган, хийж гүйцэтгэсэн арга хэмжээг албан бичгээр 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр ирүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж арилгах, давтан гаргахгүй байх.

ТАНИЛЦУУЛГА ҮЙЛДСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР

Т.ЦЭРЭГБАЯР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР

Б.ЧУЛУУНБАТ

ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН АВСАН:

ЭРДЭНЭЦАГААН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ

Г.ЭНХТУЯА
Б.ЗОЛЖАРГАЛ